

Нагоя дахь сургалтын хөтөлбөрт туссан үйл ажиллагааны товч тайлан

Огноо	Үйл ажиллагаа	Үр дүн
2017-01-28	1. Нагоя хот, Японы соёлтой танилцах	Эртний Самурай нарын Нагоя сүмтэй танилцаж, Япон үндэсний хувцас Кимоно шоуд оролцов. Мөн далайн аквариум, 60000 сардин загасны шоу, дельфины шоу тоглолтуудыг үзэж сонирхов.
2017-01-29	2. Нагоя Их сургуулийн профессоруудын лекц сонсож, тэдний зохион байгуулсан “Хичээлийн анализ” семинарт оролцох	Нагоя ИС-ийн профессор Шибата, Арани нарын хичээлийн судалгааны тухай лекц сонсов. Уг семинарт Японы их сургууль, ахлах болон бага, дунд сургуулийн 20 орчим багш, Нагоя их сургуулийн судлаач оюутнуудын оролцов. Япон болон Монголын багш нар хамтран 2016 оны 11 сард Говьсүмбэр аймгийн нэгдүгээр сургуульд заасан математикийн хичээлд “тэмдэглэлд суурилсан хичээлийн анализ” хийв. Японы багш нар хичээлийн тэмдэглэлийг уншаад, тухайн хичээлийн онцлог, давуу талуудыг хэлж, мөн сайжруулах саналууд хэлж чаддаг болтлоо хөгжсөн байгааг харахад гайхалтай байв.
2017-01-30	3. АИЧИ их сургуулийн харьяа бага сургуультай танилцах	Фүзоку бага сургуульд зочилж, сургуулийн орчин болон зарим хичээлийн явцтай танилцав. Тус бага сургууль нь жил бүр хичээлийн судалгаа зохион байгуулж, хичээлийн судалгааны тайлан бичдэг байна. Энэ сургуульд уламжлал болон тогтсон нэг дэг нь аль ч хичээл дээр сурагчид гар өргөхдөө нэг, хоёр, гурван хураагаа өргөх, гараа атгах, гараа тэнийлгэх гэх мэт таван байрлалаар гараа өргөдөг бөгөөд эдгээр нь тус бүрдээ утга илэрхийлдэг байна.
2017-01-31	4. Komakihara бага сургуульд зочлох	Энэ сургуулийн онцлог нь математикийн хичээл дээр сурагчдад стандарт түвшнээс буюу сурах бичгийн агуулгаас давсан дасгал даалгавар (Jump problem) өгч шийдүүлдэг. Ингэхдээ сурагчдын хамтран ажиллах үйл ажиллагааг хөгжүүлдэг бөгөөд сайн хүүхдээр яриулах бус тусламж хэрэгтэй хүүхдэд анхаарч, уг хүүхдэд бусад хүүхдээр тайлбарлуулах арга зүй хэрэглэдэг байна.
	5. Komaki Minami Ахлах сургуулийн судалгаат хичээлийн өдөрлөгт оролцох	Японд ахлах сургуульд хичээлийн судалгаа хийх нь ховор бөгөөд энэ сургууль ахлах ангийн уран зохиолын хичээлд судалгаат хичээл зохион байгуулж, бусад сургуулийн багш нар ирж танилцаж байв. Мөн уг судалгаат хичээлд эхний

		жилдээ багшилж буй багш нарын сургалт давхар явагдаж байгаа нь содон байлаа. Мөн уг судалгаанд тухайн мужийн боловсролын гакрын мэргэжилтэн ирж оролцож байв. Уран зохиолын хичээл дээр сурагчид 3 багаар ажиллаж Японы эртний яруу найргийг уншиж ойлгон, өөрсдийн найруулгаар жүжигчилсэн тоглолт хийж, дараа нь хэвлэлийн бага хурал зохион байгуулж буй байдлаар дүрүүдийн дотоод санааг илүү тодруулан хэлэлцэх үйл ажиллагааг төлөвлөжээ.
2017-02-01	6. МУБИС, Нагоя их сургуулийн хамтарсан хурал	Тус хуралд Боловсролын зээлийн сангийн захирал П.Лхагвасүрэн “Боловсролын зээлийн сан болон МУ-ын боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа”, МУБИС-ийн профессор Д.Нямжав “Боловсролын сэтгэл судлал”, МХСН-ийн секторын эрхлэгч Т.Ганбаатар “Монголын хичээлийн судалгааны өнөөгийн байдал”, “МХСН-ийн үйл ажиллагаа” сэдэвт илтгэлүүд, Профессор Соежима “Хамтран суралцах, active learning арга зүй”, Профессор Куно “Японы хөтөлбөрийн шинэчлэл” сэдвээр тус тус лекц уншиж харилцан хэлэлцүүлэг явуулав.
2017-02-02	7. Нагоя их сургуулийн харьяа ахлах сургуультай танилцах 8. Нагоя их сургуулийн ерөнхийлөгчтэй уулзах	Нагоя их сургуулийн харьяа ахлах сургуулийн сургалтын орчин анги танхимтай танилцав. Сурагчид нь элсэлтийн шалгат өгч буй тул цөөн хэдхэн сурагч л үлдсэн байлаа. Нагоя их сургуулийн ерөнхийлөгч МХСН-ийн сургалтын багийн гишүүдийг хүлээн авч уулзаж, хамтдаа дурсгалын зураг авахуулав.